



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Сэлэнгэ-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 13 нэрийн, нийт 92,499,268.00 (ерэн хоёр сая дөрвөн зуун ерэн есөн мянга хоёр зуун жаран найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Сэлэнгэ-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Энхболд, гүйцэтгэх захирал Л.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах, орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

300724

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ний
өдрийн 382 дугаар тогтоолын хавсралт

"Сэлэнгэ-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж,
данснаас хасах сэлбэгээр орлогод авах хөрөнгийн жагсаалт

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглал тад орсон он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэлбэгээр худалдах, орлогод авах доод үнэ /төгрөг/
1	ЗИЛ маркийн 29-34 СБА улсын дугаартай, өөрөө буулгагч, арал дугаар 000208142359505	1993	975,500.00	500,000.00
2	ЗИЛ маркийн 29-45 СБА улсын дугаартай, өөрөө буулгагч, арал дугаар 00020033358490	1990	3,165,750.00	500,000.00
3	ЗИЛ-130 маркийн 29-22 СБА улсын дугаартай, ачааны, арал дугаар 2949789	1992	300,960.00	500,000.00
4	Ниссан маркийн 09-78 СБА улсын дугаартай, ачааны, арал дугаар J2F23001047	1992	9,471,920.00	500,000.00
5	Истана маркийн 24-90 СЭА улсын дугаартай, микроавтобус, арал дугаар KPDFBDL81YP104889	1985	541,180.00	500,000.00
6	ЮМЗ маркийн 04-08 УН улсын дугаартай, трактор, арал дугаар 121928	1986	4,845,750.00	500,000.00
7	ХСМГ маркийн 92-69 УБ улсын дугаартай, зам индүү, арал дугаар 061018	1987	1,628,100.00	500,000.00
8	ДУ-147 маркийн 14-09 УН улсын дугаартай, зам индүү, арал дугаар 4024344	1999	19,800,000.00	500,000.00
9	ЗИЛ маркийн 29-26 СБА улсын дугаартай, өөрөө буулгагч, арал дугаар 00020032855092	1986	4,930,430.00	500,000.00
10	МАЗ маркийн 60-15 ТЧ улсын дугаартай, чиргүүл, арал дугаар 004971	1989	300,970.00	200,000.00
11	ЧМ маркийн 61-47 ТЧ улсын дугаартай, чиргүүл, арал дугаар 20001517	1990	2,713,500.00	200,000.00
12	ОДАЗ-885 маркийн 83-27 ТЧ улсын дугаартай, чиргүүл, арал дугаар 001	1992	34,425,208.00	500,000.00
13	ДОНГ маркийн 15-05 СЭА улсын дугаартай, ачааны, арал дугаар LGWANAN596604029	2000	9,400,000.00	500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		92,499,268.00 (ерэн хоёр сая дөрвөн зуун ерэн есөн мянга хоёр зуун жаран найман)	5,900,000.00 (таван сая есөн зуун мянга)